



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын Чандмань-Илч ОНӨХХКомпанийн 2021 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/06/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Ш.Сувдаа
		Цахим хаяг: smaudit97@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.03.18 № 16/319

танай _____ -ны № _____ -т

ЧАНДМАНЬ-ИЛЧ ОНӨХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сайншанд сумын Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сайншанд сумын Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,253.6	5,461.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	28,706.9	28,122.8
	Нийт хөрөнгийн дүн	32,960.6	33,584.5
	Нийт өр төлбөрийн дүн	15,626.7	16,389.5
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	17,333.8	17,194.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	32,960.6	33,584.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	17.1	13.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	771.1	976.1
	Үйл ажиллагааны үр дүн	(481.9)	(132.7)
	Үйл ажиллагааны бус үр дүн	(482.1)	(132.7)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(482.1)	(132.7)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,459.8	15,459.8
	Тайлант оны үр дүн	(6,370.2)	(6,509.0)
	Эцсийн үлдэгдэл	17,333.8	17,194.9
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	11,013.8	13,046.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	10,446.5	13,081.4
	Үйл ажиллагааны ЦМГ	567.2	(34.9)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(594.4)	(155.6)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	222.8	328.5
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	195.7	137.8
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	203.6	399.8
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	399.3	537.2

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайншанд сумын Чандмань-Илч ОНӨХХК-ийн зорилго нь Хэрэглэгчдийг чанартай дулаанаар, үйлдвэрлэлийн болон унд ахуйн стандартад тохирсон цэвэр усаар тасралтгүй хангаж, экологийн тэнцвэрийг хадгалах шалгуурт нийцэх усыг байгальд нийлүүлнэ.

Үйлдвэрлэл үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах орчин үеийн дэвшилтэд технологид суурилсан байгаль орчинд ээлтэй техник, технологийг үйлдвэрийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн эрсдэлгүй үйлдвэр байхад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг компани нь Монгол Улсын хуулийн дагуу зохион байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, өөрт олгогдсон хөрөнгө болон үйл ажиллагааны үр дүнд олсон орлогын үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх замаар бие даан иргэний харилцаанд оролцдог, дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, шүүх арбитрад нэхэмжлэгч хариуцагчаар оролцох эрхтэй хуулийн этгээд мөн гэж тодорхойлжээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Чандмань-Илч ХХК-ны 2020.12.25-ны 06 дугаар ТУЗ-ийн зөвлөлийн тогтоолоор Чандмань-Илч ХХК-ний 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 11,690.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 12,138.8 сая төгрөгөөр, 448.7 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 575.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Чандмань-Илч ххк байгууллага нь тайлант онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 141 мэдээллийг ил тод байршуулсан, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах, анхаарал татахуйц бусад асуудал байхгүй болно.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 530.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 417.8 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 113.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

- Борлуулалтын орлогыг 44.2 сая төгрөгөөр дутуу тусгаж тайлагнасныг аудитын явцад залрууллаа.
- ААН-ийн орлогын албан татвар, НӨАТ-ыг 4.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг аудитын явцад залрууллаа.
- Дансны ангилал зөрүүлэн 25.9 сая төгрөгийн бараа материалыг бүртгэлд тусгаж 27.9 сая төгрөгийг бараа материалын бүртгэлээс хасаж бүртгэлд тусгаж тайлагнасныг аудитын явцад залрууллаа.
- Дансны ангилал зөрүүлэн 364.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаж тайлагнасныг аудитын явцад залрууллаа.

Зөвлөмж:

Эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ОНӨ	1	1			1			
НИЙТ									

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ					-	-				
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ОНӨ	6	530.8	4	417.8					2	113.1
НИЙТ		6	530.8	4	417.8	-	-			2	113.1